



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 34

Арвайхээр

Хуралдаан товлон зарлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн ээлжит бус 4 дүгээр хуралдааныг 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 09:00 цагт хуралдуулахаар товлон зарлаж, дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1.1. 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай: Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Ц.Пүрэвсүрэн

1.2. 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай: ЗДТГазрын Газрын даамал Э.Хорлоо

2. Хурлаар хэлэлцүүлэх асуудлын бэлтгэлийг сайтар хангаж, холбогдох тооцоо, судалгааг гаргаж, төслийг 2017 оны 11 дүгээр сарын 06-нд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон Ажлын хороодод танилцуулахыг сумын Засаг дарга /О.Пүрэвдорж/, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Тунгалаг/ нарт тус тус даалгасгай.

ДАРГА



Д.АМАРТҮВШИН